



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/272

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын XIV Хуралдааны 2023 оны XIV/01 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан Усны сав газрын захиргаа, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт шаардлагатай тоног төхөөрөмж (Усны сав газрын захиргаа) нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Оч нэт" ХХК-тай 45,056,000 (дөчин таван сая тавин зургаан мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т олгосугай

2. "Оч нэт" ХХК-ийн ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Оч нэт" ХХК-ийн захирал (Т.Мөнх-Очир)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

5. Тус тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлийн хууль журмын хүрээнд бүртгэж, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад Орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ



2023 оны 04 сарын 18 өдөр бүр Дугаар А/2023/Захирамж

6323010257